



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ОНЦЛОХ АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

(“Засгийн газрын 100 хоног”-т зориулав)

2017.12.27
Улаанбаатар хот

“ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГ”-ИЙН ХУГАЦААНД ХИЙСЭН ОНЦЛОХ АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2017.12.27

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 оны 10 дугаар сараас хойш буюу “Засгийн газрын 100 хоног”-ийн хугацаанд хийж гүйцэтгэсэн онцлох ажлыг дараах байдлаар мэдээлж байна.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулав.

УИХ-ын “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төсөл, танилцуулга, Засгийн газрын “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах тухай” тогтоолын төсөл, танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. УИХ-ын “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төсөл, танилцуулгыг Монгол Улсын Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төсвийн ерөнхийлөгч нартай зөвшилцөж, дахин хуралдаанд оруулах танилцуулга боловсруулан Засгийн газарт хүргүүлэхээр бэлтгээд байна. “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах үндсэн чиглэл” батлагдсанаар Монгол Улсын төсвийн орлого тодорхой хэмжээгээр нэмэгдэх, санхүүгийн зах зээл тэлэх, компанийн санхүү болон үйл ажиллагааны чадамж нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, төсвийн ачаалал буурах зэрэг эерэг үр дүнгүүд гарна.

Төрийн бодлого, зохицуулалтын газраас “Татан буулгах хуулийн этгээдийн тухай”, “Төсөвт үйлдвэрийн газар болгох тухай”, “Өөрчлөн зохион байгуулах хуулийн этгээдийн тухай” саналыг тус тус нэгтгэн боловсруулж, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

2. Өмч хувьчлалын ажлыг зохион байгуулж, улсын төсөвт 16.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэв.

1 дүгээр зураг.



ТӨБЗГ-ын удирдлагууд “Оргил рашаан сувилал” ТӨХК-ийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан авсан иргэн Д.Ганбатад “Өмчлөх эрхийн гэрчилгээ”-г гардуулж байгаа нь

Төрийн өмчийг хувьчлах ажлын хүрээнд 2017 оны 4 дүгээр улиралд “Оргил рашаан сувилал” төрийн өмчит хувьцаат компанийг хувьчилсны орлого 15.0 тэрбум төгрөг, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Болор” амралтын газрыг худалдсаны орлого 903.0 сая төгрөгийг улсын төсвийн өмч хувьчлалын орлогод төвлөрүүлсэн бөгөөд 2017 оны нийт дүнгээр өмч хувьчлалаас нийт 16.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3. Монгол Улсын Засгийн газар “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувь эзэмшигч БНСУ-ын “Кореа Телеком” корпорацийн эзэмшиж байгаа хувьцааг худалдан авав.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 300 дугаар тогтоолоор “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 40 хувийг эзэмшигч “Кореа Телеком” корпорацийн хувьцааг тэдний санал болгосны дагуу худалдан авахаар шийдвэрлэв. Засгийн газрын энэхүү тогтоолын дагуу Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг ажиллаж, 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулав. Үүний үр дүнд, Монгол Улсын үндэсний хэмжээний томоохон компанийн үйл ажиллагааг сайжруулж, үнэлэмжийг өсгөн, нэгж хувьцааны үнийг Хөрөнгийн биржээр дахин үнэ хүргэж арилжих нөхцөл бүрдсэн.

4. Монгол Улсын Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулав.

Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 79 хуулийн этгээдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хугацаатай үүрэг чиглэл өгч ажилласан. Үүний үр дүнд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, тендер шалгаруулалтын ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллахад анхааран ажиллаж байна. Түүнчлэн, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2017 оны 11-12 дугаар сарын хугацаанд зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангахад онцгой анхаарч, арга хэмжээ авч ажилласнаар байгууллагын үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмж дээшилсэн.

5. Үндэсний газрын тос боловсруулах үйлдвэр барих ажлыг эрчимжүүлж, Монгол Улсын Засгийн газраас бүтээн байгуулалтын ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэв.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын хуралдаанд санал оруулж, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил болон төсөл хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэхээр шийдвэрлүүлэв. Уг бүтээн байгуулалтын ажлын үр дүнд, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулж, дотоодын зах зээлийг түлш, шатахуунаар хангаж, нефть-хими болон химийн аж үйлдвэрийн суурийг бий болгох зорилт хангагдана. Төслийн хүрээнд жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг түүхий тос дамжуулах хоолойн хамт байгуулж, Монгол Улс нефтийн бүтээгдэхүүний импортоос хараат бус болно.

6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үзүүлэлт эрс сайжирч, орлого, ашиг нэмэгдэн, авлага, өглөг буурав.


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшинг батлахдаа үргүй зардлыг багасгах, бодит хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалт хийх, ашиг орлого, нэмэгдэх, авлага, өглөгийг бууруулах зарчим баримталж, түүний хэрэгжилтэд хяналт тавин Монгол Улсын Засгийн газрын бодлого, чиглэлийг хэрэгжүүлж ажилласан. Үүний үр дүнд, ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит 72 хуулийн этгээдийн эдийн засгийн үзүүлэлт 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр сайжирч гарах төсөөлөлтэй байна. Тухайлбал, борлуулалтын орлого 2016 онд 1,555.1 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,797.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 15.6 хувиар буюу 242.8 тэрбум төгрөгөөр, цэвэр ашиг 2016 онд 1,105.2 сая төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,442.7 сая төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 3 дахин буюу 4,547.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Нийт авлага 2016 онд 434.7 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 312.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 28.2 хувиар буюу 122.5 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 2016 онд 1,241.2 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,201.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.2 буюу 39.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан дүнтэй байна.

Эдгээр хуулийн этгээдийн эдийн засгийн харьцуулсан үзүүлэлтийг 1 дүгээр графикт харуулав. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 13 компани, Төрийн банк, Хөгжлийн банкны дүн ороогүй болно.

Мөн урт хугацаат өр төлбөрийн дүнд 9 хуулийн этгээдийн Хөгжлийн банкинд төлөх 1,054.6 тэрбум төгрөгийн өр төлбөр орсон бөгөөд нийт өр төлбөрийн 29.8 хувийг эзэлж байна.

1 дүгээр график



2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.5 тэрбум

төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин өссөн дүнтэй байна.

7. Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчийн түрээсийн орлогыг 3.8 дахин нэмэгдүүллээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчийн илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслүүлж, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулахад анхааран, төрийн өмчийн түрээсийн нийт орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн түрээсийн орлогын талаарх мэдээллийг 2 дугаар графикт харуулав.

2 дугаар график

2017 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт төрийн өмчит 67 хуулийн этгээдийн 402 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж, түрээсийн нийт орлогоос улсын төсөвт 2.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. 2017 онд улсын төсөвт төвлөрүүлсэн түрээсийн орлогыг өнгөрсөн онтой харьцуулахад 544.8 сая байсан бол 2,090.0 сая болж 3.8 дахин нэмэгдсэн бөгөөд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2017 оны зорилтот түвшинг бүрэн хангаад байна.



8. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэв.

Төрийн өмчит 923 хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2016 оны биелэлтийг дүгнэх, 2017 оны шинэчилсэн гэрээ байгуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2016 оны биелэлтийг 5 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд улсын дундаж дүн “сайн” буюу 90.9 оноотой гарч, гэрээний биелэлтийг дунджаар 90.9 хувиар хангасан байна. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2016 оны биелэлтийн дүнгийн товчоог 1 дүгээр хүснэгтэд харуулав.

1 дүгээр хүснэгт

Төрийн өмчит хуулийн этгээдийн тоо	Улсын дундаж оноо, гэрээний биелэлтийн хувь (үндсэн шалгуур үзүүлэлтээр)					
	Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт, тайлагналтын байдал (30 оноо)	Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал (25 оноо)	Өмчийн цахим мэдээллийн системийн бүрдэл (25 оноо)	Байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийн байдал (10 оноо)	Гэрээ дүгнүүлэх бэлтгэл хангасан байдал (10 оноо)	Нийт (100 оноо, 100 хувь)
923	28.24	23.99	20.55	9.06	9.0	90.91
	94.10%	95.90%	82.20%	90.60%	90.00%	90.90%

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх, шинээр гэрээ байгуулах ажлын хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д байгууллагын санхүүгийн тайлан, хөрөнгийн мэдээлэл, бүртгэл, статистикийн мэдээ болон тэдгээрийн хөдлөл өөрчлөлт, холбогдох бусад мэдээлэл, хавсралтыг иж бүрэн тусган бүртгэж байгаа

эсэхэд хяналт тавин ажиллаж, давхардсан тоогоор 3000 гаруй албан хаагчдад өмчийн харилцааны хууль тогтоомж, эрх зүйн акт, өмчийн цахим мэдээллийн системийн талаар сургалт зохион байгуулан, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.


Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2016 оны биелэлтийг дүгнэх үеэр илэрсэн зөрчил, доголдлыг арилгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах асуудлаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж хүргүүлэхээр бэлтгэж байна.

2018 онд зохион байгуулах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх, эзэмшил газрыг үнэлж бүртгэх ажлын бэлтгэл хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

9. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн 5.7 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авав.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын 100 хоногийн хугацаанд төрийн өмчит 6 хувьцаат компани, төрийн өмчит 4 үйлдвэрийн гарын удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 5.7 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг илрүүлэв. Шалгалтын дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 10 тогтоол гарган хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаарх мэдээллийг 3 дугаар графикт үзүүлэв.

3 дугаар график



Шалгалтаар илэрсэн нийт зөрчил, дутагдлын 80 хувь нь худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчил, дутагдал эзэлж байгаа бол 20 хувийг санхүү, хөрөнгө оруулалт болон бусад асуудалтай холбоотой зөрчил, дутагдал эзэлж байна.

10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 536 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2018 онд зохион байгуулахаар болов.

Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 315 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад тусгагдсанаар 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 835.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 536 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Сүүлийн жилүүдэд тогтмол буурч байсан хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр нийгэмд тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийг сэргээхэд бодит нөлөө үзүүлэхээр байна. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын сүүлийн 6 жилийн хугацаанд зохион байгуулсан төсөл, арга хэмжээний мэдээллийг 4 дүгээр графикт харуулав. Уг мэдээллээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын өсөлт, бууралтыг дүгнэх боломжтой юм.

4 дүгээр график




11. Монгол Улсад анх удаа төрийн худалдан авалтыг “Цахим дэлгүүр”-ээр хийж, Ерөнхий гэрээ байгуулах тендерийг зарлав.

Төрийн байгууллагын урсгал зардлыг ил тод, хэмнэлттэй, үр ашигтай болгох зорилт тавьж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn> -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ийг ашиглалтад оруулан Ерөнхий гэрээг хэрэгжүүлэх төслийг үе шаттайгаар зохион байгуулж байна. Төрийн байгууллагын төсвийн урсгал зардлаар санхүүждэг байнгын хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах ажлыг эхлүүлэх хууль, эрх зүйн таатай орчин бүрдсэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 315 дугаар тогтоолоор батлагдсан 17 нэр төрлийн ерөнхий нэршлийн эмийн хэрэгцээг Монгол Улсад анх удаа Ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар нээлттэй тендерийг “Цахим дэлгүүр”-ээр дамжуулан зарлаад байна. Тендерийн нээлтийг 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр нээнэ.


12. Нээлттэй гэрээний олон улсын стандартад нийцүүлсэн Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим мэдээллийн үйлчилгээ (вэб сервис)-г хөгжүүллээ.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим мэдээллийн үйлчилгээ (<https://opendata.tender.gov.mn>)-г Нээлттэй гэрээний олон улсын стандарт (Open Contracting Data Standart)-д нийцүүлэн төхөөрөмж унших, дахин ашиглах, өгөгдөл дамжуулах боломжтойгоор хөгжүүллээ. Ингэснээр тендер шалгаруулалтын явц, гүйцэтгэл, үр дүнг бусад төрийн байгууллага (захиалагч), судлаачид болон цахим хуудас хөгжүүлэгч зэрэг хэрэглэгч, иргэд, олон нийтийн зүгээс хянах боломжтой болов. Түүнчлэн, худалдан авах ажиллагааны статистик мэдээ, мэдээллийг дараагийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах буюу төсвийн төлөвлөлттэй уялдуулах техникийн нөхцөл бүрдсэн.



Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим мэдээллийн үйлчилгээ үзүүлэх <https://opendata.tender.gov.mn> цахим систем дэх тендер шалгаруулалтын дэлгэрэнгүй мэдээллийг харуулж буй байдал

Ийнхүү Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн нээлттэй өгөгдлийн дэд бүтцийг бий болгоход өөрийн үүргээ биелүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж байна.



Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим мэдээллийн үйлчилгээ үзүүлэх <https://opendata.tender.gov.mn> цахим системд худалдан авах ажиллагааны мэдээллийн өгөгдлийг JSON форматаар харуулж буй байдал

Түүнчлэн, Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэдээллийг нийгмийн сүлжээ (twitter, facebook)-ээр дамжуулан цаг алдалгүй шуурхай түгээх боломжийг бүрдүүлж, мэдээлэл дамжуулах сувгийн тоог нэмэгдүүлэн мэдээллийн ил тод байдлыг хангаж байна.

13. Орон нутгийн өмчийн газар болон орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг шалган зааварчилж, зөвлөн туслах ажлыг гүйцэтгэв.

2017 оны 11, 12 дугаар сард Баян-Өлгий, Ховд, Хэнтий, Сүхбаатар аймагт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг ажиллаж, Орон нутгийн өмчийн газар болон тэдгээр аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаатай танилцан, шалган зааварчилж, зөвлөх туслах ажлыг гүйцэтгэв. Зөвлөн туслах ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг таниулах, төрийн өмчийн бүртгэл мэдээллийн систем, хуулийн хэрэгжилтийг хангах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөхөд чиглэсэн сургалт хийж, удирдлага, нягтлан бодогч зэрэг 280 гаруй албан хаагчийг хамруулав.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМ-ОСОР

Хянасан:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.ЭРДЭНЭХИШИГ

Боловсруулсан:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ